

УЛС ТӨРИЙН ТҮҮХ, ГАДААД БОДЛОГО

XX-XXI ЗУУНЫ ОРОС, МОНГОЛЫН ХАРИЛЦААНЫ ТҮҮХИЙН ҮЕЧЛЭЛ: МОНГОЛ УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛЫН ОЛОЛТ, БЭХЖИЛТ

Б.ЭРДЭНЭБАТ

Доктор, профессор, ШУТИС,

Механик Технологийн Сургууль

Д.Нариаа 娜仁娜<sup>2</sup>

Докторант, БНХАУ-ын Жилин мужийн Жилийн Их Сургуулийн

Төрийн Захиргааны Удирдлагын Сургууль

Түгээхүү үг: Орос, Монголын харилцаа, Монгол Улсын тусгаар тогтнол, харилцааны түүхэн үечлэл, нийгмийн шинэ тогтолцоо.

Хураангуй: Энэхүү “XX-XXI зууны Орос, Монголын харилцааны түүхийн үечлэл, Монгол улсын тусгаар тогтнол” өгүүлэлд мөнхийн хөрш хоёр том гүрэнтэй хил залгаа оршдог Монгол улс түүхийнхээ ээдрээ, нугачаатай үед ОХУ-тай хэрхэн, яаж харилцаж ирэн, Монголын тусгаар тогтнолд үзүүлсэн Орос-Монголын харилцааны нөлөө, орчин үеийн Орос, Монголын харилцааны эрх зүйн түвшин, ОХУ нь Монголтой харилцах харилцаандаа ямар чиглэлийг гол болгож байгаа талаар эрдэмтэн судлаачдын бүтээлүүдэд тулгуурлан танилцуулахыг мичлэсэн болно. Ингэхдээ Орос, Монголын харилцааны түүхэн уламжлалыг үечилж, тухайн үеэд Монгол улс тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх, баталгаажуулахад үүсч байсан түүхэн хүндрэл, саад бэрхшээлүүдийг хэрхэн яаж улс төр, дипломат яриа хэлэлцээний шугамаар амжилттай шийдвэрлэсэн болон Орос, Монгол улс харилцаагаа яаж стратегийн түшиглэлийн түвшинд хүргэсэн талаар авч үзэхийг зорьсон болно.

摘要: 本文以“20-21世纪俄蒙关系与蒙古独立”为题, 为探讨地缘政治视角结合史实分析, 梳理地处中俄两大国之间的蒙古在20-21世纪与其北邻俄罗斯(前苏联)关系的演变进程, 剖析前苏联在蒙古独立中起到的深刻影响, 介绍当代俄蒙关系的法律制度保障, 探究俄对蒙外交采取的主要方针政策。同时, 作者将俄蒙两国的传统关系阶段化分析, 详细介绍在蒙古独立初期, 蒙古为取得国际社会承认其主权独立、保障其领土完整而采取的政治斡旋、外交谈判等努力, 旨在阐释俄蒙战略伙伴关系形成路径。

本文简要扼要介绍了研究现状, 即列举目前研究俄蒙两国政治、经济等各领域关系的蒙古国及俄罗斯学者、中国学者和研究机构, 其中包括: 俄罗斯学者 В.В. Гройноронский<sup>1</sup>, Якина Галина Сергеевна<sup>2</sup>, А.Ю. Сидоров<sup>3</sup>, Е.В. Бойкова<sup>4</sup>, В.В. Кузнецов, Г.Г. Васильев<sup>5</sup>, 德国学者 Уло Баркман<sup>6</sup>, 中国学者范丽群<sup>7</sup>, 希日英, 马日图孜人<sup>8</sup>, 王胜利<sup>9</sup>等。学者们从各自角度进行了大量研究, 成果斐然。中国研究蒙古问题的研究机构主要有: 内蒙古大学蒙古学学院周边国家研究所, 内蒙古社会科学院俄罗斯蒙古问题研究所, 吉林大学东北亚研究所暨蒙古学研究所和中国蒙古国研究会。这四个研究单位至今翻译、编译、撰写了大量有关俄蒙关系的文章, 研究成果颇丰。

\*\*\*\*\*

Мөн энэхүү өгүүлэлтээ эхлэхийн өмнө Орос Монголын улс төр, эдийн засаг болоод бусад бүхий л харилцааны талаар Монголын судлаачид голдгийг талачдын судлаачид тэр дундаа ОХУ, БНХАУ-ын эрдэмтэн судлаачид, судалгааны байгууллагууд судлан, дүн шинжилгээ өгсөөр байгааг дурьдах

<sup>1</sup> В.В. Гройноронский 俄蒙关系与蒙古独立的环境、条件与影响因素[J]. 蒙古学刊, 2014(3):103-110; 当代俄罗斯对蒙古外交政策初探[J]. 蒙古学刊, 2017(3):40-47

<sup>2</sup> Якина Галина Сергеевна 研究论文: “19世纪以来俄蒙关系与蒙古经济及发展”[J]. 蒙古学刊, 2006年第36期

<sup>3</sup> А.Ю. Сидоров 俄罗斯2010年与苏联关系正常化进程与历史条件的研究[J]. 蒙古学刊, 2015年第4期

<sup>4</sup> Е.В. Бойкова 21世纪俄蒙关系与伙伴关系形成[J]. 蒙古学刊, 2010(1)

<sup>5</sup> В.В. Кузнецов, Г.Г. Васильев 中蒙关系条件下俄蒙合作前景[J]. 蒙古学刊, 2010(1), 从蒙古学刊, 2009年

<sup>6</sup> Уло Баркман 蒙古内情中出现的蒙古国家以及蒙古国家制度能持续[J]. 蒙古学刊, 2007年第4期

<sup>7</sup> 范丽群 中国内情中出现的蒙古国家以及蒙古国家制度能持续[J]. 蒙古学刊, 2007年第4期

<sup>8</sup> 希日英 蒙古与俄罗斯双边关系现状特点及未来发展[J]. 蒙古学刊, 2011(1)

<sup>9</sup> 王胜利 蒙古与俄罗斯双边关系现状特点及未来发展[J]. 蒙古学刊, 2011(1)

<sup>10</sup> 马日图孜人 蒙古与俄罗斯双边关系现状特点及未来发展[J]. 蒙古学刊, 2011(1)

нь зүйтэй болов уу. Тухайлбал: ОХУ-ын судлаач В.В. Грайноронский<sup>10</sup>, Яскина Галина Сергеевна<sup>11</sup>, А.Ю. Сидоров<sup>12</sup>, Е.В. Бойкова<sup>13</sup>, В.В. Кузнецов, Г.Г. Васильев<sup>14</sup>, ХБНГУ-ын судлаач Удо Баркманн<sup>15</sup>, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Их Сургуулийн Монгол судлалын тэнхимийн хятад улстай ойролцоох улсуудын сургалт судалгааны төв, ӨМӨЗО-ны Нийгмийн Шинжлэх Ухааны Академийн Орос, Монголын асуудал судалгааны төв, Жилиний Их Сургуулийн Зүүн Хойд Азийн судалгааны төвийн Монгол улс судалгааны төв, БНХАУ-ын Монгол улс судалгааны нийгэмлэг зэрэг байгууллагуудаас гадна БНХАУ-ын ӨМӨЗО-ны Нийгмийн Шинжлэх Ухааны Академийн Орос, Монголын асуудал судалгааны төвийн судлаач Фан ли жунь 范丽君<sup>16</sup>, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Зүүн Хойд Азийн судалгааны төвийн судлаач Ши ри мө 希 日莫, судлаач Вү ри тү мү рен 乌口图牧人<sup>17</sup>, БНХАУ-ын Жилин мужийн Жилиний Их Сургуулийн дэд захирал, профессор Ванг шен жин 王胜今<sup>18</sup> зэрэг зарим судалгааны байгууллага, судлаачдын бүтээлд зохих хэмжээгээр тусгагдан судлагдсаар байна.

### *1 үе. Туурга тусгаар Монгол орон (1911-1939 онууд)*

1911 оноос өмнө Монголын газар нутаг дээр Манжийн төр улс буюу Дай Чин улс оршин тогтнож байсан юм. Монголчууд 1911 онд Чин улсаас тусгаар тогтнон, төр улсаа төвхнүүлэн тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж Богд хаант Монгол улс болон бие даасан билээ. Тусгаар тогтнолынхоо гарааг хийсэн Гадаад Монголын хил хягаар нь 1915 оны Хятад, Орос, Монгол гурван улсын Хиагтын гэрээний 11 дүгээр зүйлд зааснаар: “Өөртөө эзэрхсэн Гадаад Монголын газар нь болбоос ...урьдах Хүрээний сайд, Улиастайн жанжин, Ховдын сайдын захиргаанд байсан газрууд бөгөөд Думдал улстай нийлсэн хил болбоос Зүүн зүгт Хөлөн буйрын хязгаар, Өмнө зүгт Дотоод Монгол, Баруун өмнө зүгт Шинжиян мужийн хавь, Баруун зүгт Алтайн хязгаар дугаа зах нийлсэн Халхын 4 аймаг ба Ховдын хязгаарын олон хошуудын хилээр баймой”<sup>19</sup> гэж тодорхойлогддог. Түүнээс хойш 1945 он хүртэл Монголын хилийн тухай асуудлыг нарийвчлан авч хэлэлцсэн удаагүй байна.

1911 онд Монгол улс тусгаар тогтнолоо тунхаглаж, 1915 оны гурван улсын Хиагтын гэрээгээр Монгол улс зөвхөн Халх дөрөв, Ховдын хязгаарын нутгаар хязгаарлуулж, 1921 онд мөн энэ хэмжээнд тусгаар тогтнолоо дахин сэргээж, өөрийн бие даасан байдлаар оршиж байсан нь түүхэн бодит байдал билээ.

Монгол Улсын 1911 онд тунхаглан зарласан тусгаар тогтнолыг батжуулахад 1921 оны Ардын хувьсгал чухал үүрэг гүйцэтгэж Монгол Улсыг түүхийн шинэ үйл явцад төр улсаа байгуулан, олон улсын харилцааны субъект болох нөхцлийг бүрдүүлсэн юм. Газар зүйн онцлог байршлын улмаас их гүрнүүдийн улс төр-стратегийн ашиг сонирхлын өрсөлдөөн идэвхжсэн Монгол орны түүхэн ээдрээтэй нөхцөлд Ардын засгийн газар “үндэсний тусгаар тогтнолоо сэргээх зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө Зөвлөлт Орос Улстай нөхөрлөх нь чухал” гэсэн шийдвэр гаргаж, өөрийн орны туурга тусгаар байдлыг бэхжүүлэх, улс төр, нийгмийн шинэ тогтолцооны үндсийг тавьж, ахиулахад чиглэсэн бодлого, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байжээ. Энэ шийдвэрийн дагуу Монгол Улс 1921 оны 10 дугаар сард Зөвлөлт Орос Улсад төлөөлөгчөө явуулан хэлэлцээ хийж 1921 оны

<sup>10</sup> В.В. Грайноронский. Орос Монголын орчин үеийн харилцааны тулгамдсан асуудлууд. Олон улс судлал сэтгүүл. УБ., 2014 он №1.

Орчин үеийн Монгол улсын талаарх Орос улсын баримтлаж буй бодлогын зарим асуудал. Стратег судлал сэтгүүл. УБ., 2007 он № 40

<sup>11</sup> Яскина Галина Сергеевна. Российско-Монгольское партнерство в первом десятилетии нового века. Роль внешнего фактора в экономическом развитии Монголии. Стратег судлал сэтгүүл. УБ., 2006 он №36

<sup>12</sup> А.Ю. Сидоров. Геополитика и идеология в Советско-Монгольских отношениях в 1930-х гг. Стратег судлал. УБ., 2005 он № 4

<sup>13</sup> Е.В. Бойкова. Орос ба Монгол: XXI зуун дахь түншлэлийн харилцаа. Монгол, Орос, Хятад. XXI зуунд хөгжлийн төлөө хамтдаа. УБ., 2009 он.

<sup>14</sup> В.В. Кузнецов, Г.Г. Васильев. Глобализацийн нөхцөлд Орос-Монголын хамтын ажиллагааны тулгамдсан асуудал. Монгол, Орос, Хятад. XXI зуунд хөгжлийн төлөө хамтдаа. УБ., 2009 он

<sup>15</sup> Удо Баркманн. Орос, Хятад хоёрын дундах Монгол орон буюу Монгол улс өв уламжлалаа хадгалан хамгаалах зайлшгүй шаардлагатай болох нь. Стратег судлал сэтгүүл. УБ., 2007 он № 40

<sup>16</sup> Фан ли жунь 范丽君. Орос, Монгол хоёр улсын харилцааны өнөөгийн нөхцөл байдал ба ирээдүйн хөгжил. БНХАУ-ын Монгол улсын судалгаа сэтгүүл. Хөх хот, 2011 он.

<sup>17</sup> Ши ри мө 希日莫, Вү ри тү мү рен 乌口图牧人. Орос, Монголын харилцааны өөрчлөлт болон БНХАУ-д нөлөөлж буй байдал. БНХАУ-ын Монгол улсын судалгаа сэтгүүл. Хөх хот, 2012 он.

<sup>18</sup> Ванг шен жин 王胜今. Монгол улсын эдийн засгийн хөгжил ба зүүн хойд азийн олон улсын бүс нутгийн хамтын ажиллагаа. «Монгол улсын эдийн засгийн гадаад харилцаа ба зүүн хойд азийн бүс нутгийн хамтын ажиллагаа» сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын дагуу гаргасан илтгэлийн эмхтгэл. Чанчунь., 2009 он.

<sup>19</sup> Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ (Өдөр тутмын тэмдэгтэд) Баримт бичгийн эмхтгэл. Эмхтгэж, тайлбар бичсэн О.Батсайхан, УБ., 1999 он, 208 дахь тал

11 дүгээр сарын 5-ны өдөр, тухайн үеийн монголын цаг тооллоор Олноо ергөгдсөний 11 оны намрын адаг сар буюу 10 дахь сарын шинийн 6-ны өдөр "Монгол, Оросын хооронд найрамдлын барилдлагааг байгуулах тухай Монголын Ардын Засгийн Газар ба Зөвлөлийн Засагт Орос Улсын Засгийн Газрын хэлэлцэн тогтоосон гэрээ бичиг" буюу бидний одоогийн томъёоллоор бол "Монгол Улс, Орос Улсын хооронд найрамдалт харилцаа тогтоох тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т гарын үсэг зурсан юм.

Монгол Улсаас гадаад улстай эрх тэгш зарчимд тулгуурлан байгуулсан анхны энэхүү хэлэлцээр нь хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны хамгийн эгзэгтэй үеийн эрх зүйн чухал суурь баримт бичиг болсон бөгөөд түүгээр бүрэн эрхт дипломат болон консулын төлөөлөгчөө харилцан солилцохоор тохирч, дипломат харилцаа тогтоосон нь Орос Монгол хоёр улс бие биеийнхээ бүрэн эрхт байллыг хүлээн зөвшөөрсөн хэрэг гэж олонхи судлаачид үздэг нь эрх зүйн бүрэн үндэслэлтэй дүгнэлт юм.

Хэлэлцээрийн дагуу хоёр улс дипломат харилцаа тогтоож, 1922 онд Нийслэл хүрээнд болон Москва хотод Элчин сайдын яамдаа харилцан нээсэн нь шинэ Монгол Улсыг гадаад улс хүлээн зөвшөөрсөн анхны үйл хэрэг байсан бөгөөд цаашид Монгол Улсын тусгаар тогтнолыг баталгаажуулах үндэс суурийг тавьснаараа түүхэн их ач холбогдолтой үйл явдал болжээ.

Монгол Улсын Зөвлөлийн Засагт Орос Улстай тогтоосон цаашдын харилцаа, нягт хамтын ажиллагаа нь хэд хэдэн үе шаттай хэрэгжсэн бөгөөд 1936 онд хоёр улсын хооронд байгуулсан хамтран ажиллах, харилцан туслалх тухай гэрээ нь Монгол Улсад гадны түрэмгийлэл бодитойгоор заналхийлсэн үед Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах хамтын ажиллагааны үндэс болсон юм.

1920-оод онд Зөвлөлийн Засагт Орос Улсаас үзүүлсэн олон талт туслалж, дэмжлэг Монгол улсыг тусгаар тусгаар тогтнолоо бэхжүүлэх анхны алхамуудад чухалдүрэг гүйцэтгэсэн бол 1930-аад онд Зөвлөлийн Засагт Орос Улстай тогтоосон харилцаандаа тулгуурлан өөрийн байнгын зөвсөгт хүчнээ байгуулсанаар 1939 онд Халх голын орчмоор Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд цэргийн хүчээр халдан довтолсон Японы түрэмгийлэгчдийн халдлагыг хамтын хүчээр няцааж, Дэлхийн II дайны өрнөлийг 2 улсын зүүн талд ашигтай байдлаар намжааж чадсан юм. Түүхийн энэ хүнд шалгуураар Орос Монголын найрамдалт харилцаа зузаарч бэхэжсэн ч туурга тусгаар Гадаад Монгол улсын тусгаар тогтнолын асуудал генералиссимус Чан Кайшигаар удирдуулсан БНХУ-аар хүлээн зөвшөөрөгдөөгүй нээлттэй хэвээр байлаа.

### *III үе. Дэлхийн II дайн ба Монголын статүскво (1939 – 1946 онууд)*

Оросын ард түмэн хүнд хэцүү үед Монголын ард түмэнд туслалжийн гараа сунгаж, халуун сэтгэлээр харамгүй туслалж байсан бол 1941-1945 оны Аугаа Их Эх Орны Дайны жилүүдэд Монголын ард түмэн ах дүүгийн найрамдалт харилцаандаа үнэнч байж өөрийн хүч бололцооны хэрээр Зөвлөлтийн ард түмэн, түүний армид туслалж Монголын ард түмний хөрөнгөөр бий болгосон "Хувьсгалт Монгол" танкийн цуваа, "Монгол Ард" нисэх эскадриль, олон мянган агт морьд, хувцас хэрэгсэл, үнэт эдлэлийг Зөвлөлтийн армид бэлэглэж байлаа. Олон арван вагоноор хэмжигдэх Монголын ард түмний чин сэтгэлийн энэхүү туслалж дэмжлэг тус хоёр орны найрамдалт харилцааг чухамхүү нягтруулсан юм.<sup>21</sup>

Дэлхийн хоёрдугаар дайны төгсгөлийн үеэр Ялтад болсон дэлхийн гурван их гүрний тэргүүн нарын уулзалтын нэгэн чухал асуудал нь Монголын тусгаар тогтнолын тухай асуудал байсан билээ.

1945 оны 2 дугаар сарын 11-ны өдөр ЗСБНХУ, АНУ, Их Британи "Гурван их гүрний удирдагч И.Сталин, Ф.Рузвельт, У.Черчилль нарын Алс Дорно дахины багц асуудлаар хийсэн хэлэлцээрийн удиртгал хэсэгт "Европт дайн дуусч, Герман бууж өгсөнөөс 2, 3 сарын дараа ЗХУ холбоотнуудын талд Японы эсрэг дайнд орно. Харин үүний нөхцөл болгож" хэмээн өгүүлээд гурван зүйл тавьсаны нэгдүгээр зүйлд заахдаа; "Гадаад Монголын (БНМАУ) статүс квот хадгалах явдал"<sup>22</sup> хэмээн заасан байна. Энэ асуудлыг Зөвлөлт их гүрний тэргүүн И.Сталин оруулж ЗХУ, АНУ, Их Британи гурван их гүрний тэргүүн нар Монголын статүс квот (status quo) «одоогийн байгаагаар» хадгалахаар тохиролцсон нь Манай улсын тусгаар тогтносон байдал олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдөх үндэс нь болсон юм.<sup>22</sup> Чингэхдээ Ар Монголд хамаарах хэлэлцээрийн энэ заалт нь генералиссимус Чан Кайшигаас зөвшөөрөл авахыг шаардаж байсан бөгөөд маршал Иосиф Сталины зөвлөснөөр

<sup>21</sup> Стратегийн судлал сэтгүүл 2008 оны № 43, хэвлэл ху 84-85

Г.Лүндэн / БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн цэргийн гадаад харилцааны асуудал хариуцаж зөвлөх/ "Монгол, Оросын цэргийн харилцаа" нийтлэлээс

<sup>22</sup> Крымская конференция руководителей трех союзных держав - СССР, США, Великобритании (3-11 февраля 1945 г.) Сборник документов., М., Политиздат., 1979, с. 273-274

<sup>23</sup> Крымская конференция руководителей трех держав СССР, США и Великобритании 4-11 февраля 1945г., М., 1984, с.255

АНУ-ын Ерөнхийлөгч Теодор Рузвельт тэрхүү зөвшөөрөл өгөгдсөн байх бүхий л арга хэмжээг авах болно хэмээн протоколд тэмдэглэгдэж үлджээ.<sup>23</sup>

Т.Рузвельтийн дараах АНУ-ын ерөнхийлөгч Гарри Трумэн ч бас хэлэлцээрийн заалт ёсоор энэ шийдвэрийг биелүүлэхэд анхаарлаа хандуулан ажиллаж байжээ. Жишээ нь, түүний илгээсэн “Зөвлөлтийн тавьсан нөхцөлийг Чан Кайшид мэдэгдэж, улмаар түүний зөвшөөрлийг авахыг Элчин сайд Хэрлид үүрэг болголоо. Мөн түүнчлэн АНУ-ын Засгийн газар Ялтын хэлэлцээрийг баритлах болно гэдгийг генералиссимус т мэдэгдэх заавар Элчин сайд Хэрлид өгсөн” тухай маш нууц цахилгаан утсыг маршал Сталин 1945 оны 6 дугаар сарын 15-нд хүлээн авч байжээ.<sup>24</sup>

Ингээд 1945 оны 6 дугаар сарын 30-наас 1945 оны 8 дугаар сарын 14-нийг дуустал хугацаанд БНХУ-ын Засгийн газрын Ерөнхий сайд Сун Цзы Вэнь тэргүүтэй төлөөлөгчид Иосиф Виссарионович Сталин тэргүүтэй Зөвлөлт Холбоот Улсын удирдагч нартай хийсэн Зөвлөлт Хятадын хоорондох хэлэлцээрийн нэг үндсэн асуудал нь Монголын статус квог хүлээн зөвшөөрүүлэх асуудал орсон байна.

И.Сталинтай хийсэн гурав дахь удаагийнхаа уулзалтаар Сун Цзы Вэнь “Хятадын засгийн газар Монголын статус-квог хүлээн зөвшөөрөхийг зөвшөөрч”<sup>25</sup> байгаагаа мэдэгдээд, “Гадаад Монголын талаарх Зөвлөлтийн бодлогыг “БНМАУ-ын нутаг дэвсгэрт Зөвлөлтийн цэрэг оруулах ЗХУ-ын байр суурь” хэмээн ойлгож байгаагаа илэрхийлэхэд нь И.Сталин “Зөвхөн энэ бодол төдий бус мөн монголчууд өөрсдөө Хятадын бүрэлдхүүнд үлдэхийг хүсэхгүй байна, тэд мөн ЗХУ-ын бүрэлдэхүүнд ч мөн адил орохыг хүсэхгүй байна. Тэд тусгаар тогтносон байхыг хүсэж байна”<sup>26</sup> хэмээн Монголчуудын байр суурийг тодорхойлж байжээ. И.Сталин хэлэлцээрийн явцад хэд хэдэн удаа монголчуудын өмнөөс мэдэгдэл хийж байсан бөгөөд үүнд мэдээж БНМАУ-ын удирдагч нартай ойр дотно байсан сайн харилцаа нөлөөлсөнөөс гадна Алс Дорнод дахь ЗСБНХУ-ын эрх ашгийн асуудал байсан нь зүйн хэрэг.

И.Сталин Сун Цзы Вэнь нарын тавь дахь уулзалт<sup>27</sup> дээр Сун Цзы Вэний “БНМАУ-ын тусгаар тогтнолыг Хятад улс хүлээн зөвшөөрөхөд бэлэн”<sup>28</sup> гэсэн хариултын дараа И.Сталин Хятадын нот дахь томъёоллыг “Японыг ялагдсаны дараа, санал хураалтын дараа БНМАУ-ын тусгаар тогтнолыг одоогийн байгаа хил хязгаарт нь Хятадын засгийн газар хүлээн зөвшөөрч байна.”<sup>29</sup> хэмээн тодорхойлбол бүр илүү болно” гэж хэлж байжээ. Энд тэмдэглэхэд Монгол улсын статус квог тусгагдсан хилийг 1915 оны Хятад, Орос, Монгол гурван улсын Хиагтын гэрээний 11 дүгээр зүйлд үндэслэсэн байна.

1945 оны 8 дугаар сарын 13-ны өдөр И.Сталин Сун Цзы Вэнь нарын 9 дэх удаагийн уулзалт болж, уулзалтын эхэнд Сун Цзы Вэнь сүүлчийн уулзалтын тухай Чан Кайшид мэдээлж хариу авсанаа илэрхийлээд “БНМАУ-ын тусгаар тогтнолыг оршин буй хил хязгаарын хүрээнд хүлээн зөвшөөрөхийг Чан Кайши зөвшөөрч байна”<sup>30</sup> хэмээн мэдэгджээ.

И.Сталин Сун Цзы Вэний саналыг хүлээн авч, хэдхэн өдрийн дараа батлагдах Найрамдал, хамтын ажиллагааны тухай Гэрээг соёрхон баталсаны дараа БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх тухай мэдэгдэл нь хүчин төгөлдөр болох учиртай<sup>31</sup> хэмээжээ.

Ийнхүү бүтэн хагас сар үргэлжилсэн Зөвлөлт Хятадын хэлэлцээр дуусч, гэрээ хэлэлцээрүүдэд 1945 оны 8 дугаар сарын 14-ний өдөр гарын үсэг зурсаны<sup>32</sup> дотор Гадаад Монголын тусгаар тогтнолын тухай хэлэлцээр орсон юм.

<sup>23</sup> С.Г.Лузянин Ялтинская конференция и проблемы международного-правового оформления МНР накануне и в годы второй мировой войны – Проблемы Дальнего Востока 1995, И 6

<sup>24</sup> Переписка председателя Совета министров СССР с президентами США и премьер-министрами Великобритании во время Великой Отечественной войны 1941-1945 гг. т.второй М., 1957, с. 243

<sup>25</sup> Архив Внешней политики Российской Федерации ф.45, Оп 1, д.322, л.19-27

<sup>26</sup> Мөн тэнд 23 дахь тал

<sup>27</sup> Запись пятой беседы И.В.Сталина с Председателем Исполнительного юаня и министром иностранных дел Сун Цзывэнем на советско-китайских переговорах в Москве в ходе обсуждения вопросов статуса Монгольской Народной Республики, Порт Артура и Дайрена, КВЖД и ЮМЖД 11 июля 1945 года- Сборник документов Русско китайские отношения в XX веке. Т.4. Советско- китайские отношения. 1937 -1945гг. Кн.2., 1945г. Отв.ред. С.Л Тихвинский. М., Памятники исторической мысли., 2000., - с.124 -131

<sup>28</sup> Мөн тэнд 125 дахь тал

<sup>29</sup> Мөн тэнд 125 дахь тал

<sup>30</sup> Запись девятой беседы И.В.Сталина с Председателем Исполнительного юаня и министром иностранных дел Сун Цзывэнем на советско-китайских переговорах в Москве в ходе обсуждения вопросов статуса Монгольской Народной Республики, Порт Артура и Дайрена, КВЖД и ЮМЖД 13 августа 1945 года- Сборник документов Русско китайские отношения в XX веке. Т.4. Советско- китайские отношения. 1937 -1945гг. Кн.2., 1945г. Отв.ред. С.Л Тихвинский. М., Памятники исторической мысли., 2000., - с.182 -184

<sup>31</sup> Мөн тэнд 182 дахь тал.

<sup>32</sup> Мөн тэнд 187 -198.

Гадаад Монголын тусгаар тогтнолын тухай ЗСБНХУ-ын Гадаад хэргийн ардын комиссар В.М.Молотовт ирүүлсэн БНХУ-ын Засгийн газрын нот<sup>33</sup> бичигт: “Гадаад Монголын ард түмнээс тусгаар тогтнолынхоо төлөө нэг бус удаа илэрхийлсэн эрмэлзлэлийг харгалзан үзэж, Японыг ялагдсаны дараа хэрэв Гадаад Монголын ард түмний санал хураалт энэ эрмэлзлэлийг нотлох аваас Гадаад Монголын тусгаар тогтнолыг оршин буй хил хязгаарт нь Хятадын засгийн газар хүлээн зөвшөөрч байна хэмээн Хятадын Засгийн газар мэдэгдэж байна” гэсэн бол, Гадаад Монгол (БНМАУ)-ын тусгаар тогтнолыг Бүгд Найрамдах Хятад Улс хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Бүгд Найрамдах Хятад Улсын Засгийн газарт ЗСБНХУ-ын Засгийн газраас өгсөн хариу нот<sup>34</sup> бичигтээ: “Бүгд Найрамдах Хятад улсын Засгийн газрын дээрх нотыг сэтгэл хангалуун хүлээн авч, өөрийн талаас Зөвлөлт Засгийн газар цаашдаа ч БНМАУ-ын (гадаад Монгол) улс төрийн тусгаар тогтнол ба газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх болно гэдгээ мэдэгдэж байна” гэсэн байна.

Ийнхүү Монголын тусгаар тогтнолыг БНХУ хүлээн зөвшөөрсөн Зөвлөлт Хятадын энэхүү хэлэлцээр өндөрлөсөнөдөр ЗСБНХУ Японд дайн зарласантай өдөртэй давхцан таарч тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлсэн Монгол улсын цэрэг, дайчид Оросын улаан армитай хамтран Алс Дорнодыг чөлөөлөх дайнд оролцож, Дэлхийн II дайныг дуусгахадхувь нэмэрээ оруулсан юм.

Энэ бүхний үрдүнд 1945 оны 10 сарын 20-нд Монгол улс орон даяар санал асуулга явуулж, Монголын ард түмэн тусгаар тогтнолынхоо төлөө 100 хувь саналаа өгсөн юм. Санал асуулгын дүнг хүлээн аваад 1946 оны 1 сарын 6-нд Чан Кайшигийн Засгийн газар БНМАУ-ыг хүлээн зөвшөөрч, улмаар мөн оны 2 сарын 10-нд Хятад Монголын хооронд дипломат харилцаа тогтоох болон дипломат төлөөлөгч харилцан суулгах тухай ноот бичгүүдээ солилцжээ.

Үүний дараа ЗСБНХУ ба БНМАУ-ын хооронд найрамдал, хамтын ажиллагааны тухай гэрээ байгуулах асуудлаар БНМАУ-ын Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсан 1946 оны 2 дугаар сарын 22-ны өдөр И.Сталинтай уулзсануулзалтын<sup>35</sup> БНМАУ-ын тусгаар тогтнолыг Хятад хүлээн зөвшөөрсний дараа болж байгаагаараа нилээд онцлог байлаа. Энэ уулзалтын үеэр генералиссимус И.Сталин хэлэхдээ: “Протокол ёсоор бид (Зөвлөлтийн тал) БНМАУ-аас цэргээ гаргах учиртай. Гэвч Чойбалсан үүнийг хэрхэвч хийхгүй байхыг гуйсан, учир нь БНМАУ-ын нутаг дэвсгэрт Улаан армийн бие бүрэлдхүүн байх нь тус орны энх амгалан байдлын баталгаа болж байгаа юм”<sup>36</sup> гээд 1936 оны 3 дугаар сарын 12-ны Харилцан туслалцах тухай протоколыг гэрээ болгон гарын үсэг зурах саналыг тавьсан байна.

Энэ уулзалтаар харилцан тохиролцсон ёсоор 1946 оны 2 дугаар сарын 27-нд ЗСБНХУ ба БНМАУ-ын хооронд найрамдал, харилцан туслалцах тухай гэрээ, Эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр Москва хотноо байгуулж, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн газрыг төлөөлж В.Молотов, БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн газрыг төлөөлж Х.Чойбалсан нар гарын үсэг зуржээ<sup>37</sup>. Энэхүү гэрээ, хэлэлцээр нь БНМАУ ба ЗСБНХУ хоёрын найрамдал, хамтын ажиллагааг хөгжүүлж, Монгол улсын хувьд дэлхийн тавцанаа гарах, олон улсын хувьд хүлээн зөвшөөрөгдөх бүрэн үндэслэл болсон байна.

Ийнхүү хоёр улсын хооронд гэрээ байгуулагдсантай холбогдуулан 1946 оны 3 дугаар сарын 9-нд Зөвлөлтийн удирдагчдын тэргүүн И.Сталин түүхт хоёр үйл явдлыг онцолжтэмдэглэн хэлэхдээ “... Бүгд Найрамдах Монгол Ардын Улс нь үнэн хэрэг дээрээ тусгаар тогтнолыг олж авахаар үл барам харин өөрийн тусгаар тогтнолыг албан ёсоор зөвшөөрүүлсэн нь түүхт явдал мөн... Хоёрдугаар түүхт явдал нь ЗСБНХУ ба БНМАУ хоёрын хооронд нөхөрлөл ба харилцан туслалцах гэрээ байгуулсан явдал мөн юм. Үүний урьд манай хооронд харилцан туслалцах протокол байсан бол одоо түүнийг гэрээ болгон хувиргасан болно. Энэ бол их түүхт явдал мөн. Энэ явдлын утга нь юунд орших вэ гэвэл хэрэв БНМАУ-ын хажуу талаас довтлох бол ЗСБНХУ-ын зэвсэгт хүчин нь Монголд түүний тусгаар тогтнолыг хамгаалах явдалд нь туслах юм. Энэ нь ямар нэгэн этгээдээс Бүгд Найрамдах Монгол Ард Улсад довтолбол, тэр этгээд нь бидэнтэй, Зөвлөлт Холбоот Улстай тулгарна гэсэн хэрэг юм”<sup>38</sup> гэжээ.

Дэлхийн II дайн дууссаны дараа 1946 онд байгуулсан гэрээ нь Монгол Улсын бүрэн эрхийг олон улсын хэмжээнд баталгаажуулсан, Монгол Улс энхийн үйлсэд шилжиж, сонгосон замаараа замнах идэвхтэй хөгжлийг дэмжсэн гэрээ байлаа.

<sup>33</sup> Сборник документов Русскокитайские отношения XX века Т.4, Советско-китайские отношения. 1937–1945гг. Кн.2., 1945г. Отв.ред. С.Л.Тихвинский. М., Памятники исторической мысли., 2000. – с.198, Правда., 1945 года. 27 августа

<sup>34</sup> Мөн гэнд 198 дахьтал, Правда 1945 г 27 августа.

<sup>35</sup> Запись беседы И.Сталина с Премьерминистром МНР Чойбалсаном 22 февраля 1946 года- Үндэсний төв архив ф.445, д.2, х.н.63., 1-4 дэх тал.

<sup>36</sup> Мөн тэнд 1 дэх тал.

<sup>37</sup> Монгол-зөвлөлтийн харилцаа. 1921-1974, Хоёрдугаар боть. 1941-1974. нэгдүгээр хэсэг, УБ., 1981. 156 дахь тал.

<sup>38</sup> Сталин Чойбалсан нарын уулзалтын тэмдэглэл 1946 оны 3 дугаар сарын 9-ны өдөр МАХН-ын архив.

Үүнээс дүгнэж хэлэхэд Дэлхийн II дайнд ялсан хүчирхэг гүрнүүдийн удирдагчдын хэмжээнд “Монголын статус кво” нэртэйгээр шийдэгдсэн энэтүүхэн процесс Гадаад Монголчуудын хувьд маш том хувь завшаан, тусгаар тогтнолоо баталгаажуулсан чухал алхам болсоныг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Өөрөөр хэлбэл Орос Монгол хоёр улс 1921 оны хэлэлцээрээр тогтоосон найрамдалт харилцаагаа дайны жилүүдэд батжин зузааруулж, энэ найрамдлын үр шим нь дайнд ялсан их гүрнүүдийн удирдагчдын хэлэлцээрт тусгалаа олж, тусгаар тогтнолоо зөвшөөрүүлсэн нь Монгол улсын түүхийн он тоололд хэзээд гялалзан үлдэх нь дамжиггүй.

### ***III үе. Социалист системийн гишүүн орон БНМАУ (1946-1991 онууд)***

Монголын тусгаар тогтнолд шийдвэрлэх нөлөө бүхий олон үйл явдалд оролцсон шигээ Монгол Улсыг 1961 онд нилээн бэрхшээл туулан байж НҮБ-ын гишүүн болоход НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн гишүүн орон ЗХУ, БНХАУ хоёр онцгой нөлөөтэй оролцсон юм.

Үүний дараахан ЗХУ-тай хийгдсэн 1966 оны “Найрамдал, хамтын ажиллагааны тухай гэрээ” нь Дэлхий дахинд Монгол Улсын бүрэн эрхт байдал баталгаажсны дараа нийгэм эдийн засгийг нь хөгжүүлэхэд эрчимтэй хамтран ажиллах үндсийг бүрдүүлсэн. Монгол орныг үйлдвэржүүлэх, эдийн засгийн хүчин чадлыг эрс нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйг механикжуулах, хот тосгодыг барьж байгуулах олон бүтээн байгуулалтууд чухам энэ үед өрнөсөн.

1960-1990 онуудад ЗХУ БНМАУ-ын хувьд гадаадын гол түшиг тулгуур, үндэсний аюулгүй байдлыг батлан хамгаалах холбоотон, нийгмийн бүтээн байгуулалтын ерөнхий загвар, туслах гол донор улс байсан.<sup>39</sup>

1980-аад ондуудад ЗХУ-д явагдсан өөрчлөн байгуулалт олон талын хүндрэл бэрхшээлтэй учирч дотооддоо эдийн засгийн тогтворгүй байдал үүсч, санхүү, хууль эрх зүйн болон гүйцэтгэлийн бусад салбарууд авилгалд идэгдэн хүчгүйдэж байлаа. Гэсэн хэрнээ гадаад харилцаандаа дан ганц өрнөдийнхөнд түшиглэсэн чиг бодлогыг явуулж байсан нь Орос Монголын харилцааг зогсонги байдалд оруулсан юм.<sup>40</sup>

ЗХУ задрахаас өмнө 1991 оны 2 дугаар сарын 12-нд Монгол Улсын Ерөнхий сайдыг Орос Улсад айлчлах үед “Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Орос Улсын Найрамдал, сайн хөршийн хамтын ажиллагааны тухай Тунхаглал” гаргасан юм. Уг баримт бичиг хоёр улсын “эдийн засаг, улс төрийн тогтоолцоонд болон хоёр талын хамтын ажиллагааны механизмд гарч байгаа гүнзгий өөрчлөлтүүд хоёр улсын хооронд янз бүрийн түвшинд хэлхээ холбоо, харилцан ажиллагааг эрчимжүүлэхэд шинэ боломж нээж, тус дөхөм болж байгааг харгалзан”, хамтын ажиллагааны чиглэл, механизмыг тодорхойлохыг тухайн үед оролджээ. Гэвч энэ тунхаглал хэрэгжиж чадалгүйгээр нийгмийн өөрчлөлт, шилжилтийн давалгаанд цохигдож, удалгүй ЗХУ задарч социалист системийн орнуудыг нэг бодлогод барьж байсан үүрэг, функц нь алга болж оронд нь Оросын Холбооны Улс шинээр бүрэлдэн тогтлоо. Шилжилтийн үед Орос Монгол хоюулаа системийн гүнзгий хямралд нэг зэрэгнэвэгдэж үйлдвэрлэл, аж ахуй, худалдаа, эдийн засаг, соёл урлаг, шинжлэх ухаан зэрэгт хуучин хэвийн харилцаа холбоо ихээхэн алдагдаж зарим салбарт бараг тасарсан билээ. ЗХУ-ыг орлон үлдсэн Оросын Холбооны Улс урьдын адил Монгол улсын нэг найрсаг, сайн хөрш улс хэвээр үлдсэн ч Оросын зүгээс Монгол руу чиглэсэн харилцаа энэ үед яагт ч үгүй зогсонги байдалд орсон юм.<sup>41</sup> Ийнхүү өнгөрсөн зууны 80-90-ээд оны зааг дээр Дэлхий дахинд гарсан эргэлтийн чанартай үйл явдлууд, түүний дотор Орос болон Монгол улсад өрнөсөн ардчилсан өөрчлөлтийн дүнд Монгол Улс болон ЗХУ-ын өвийг залгамжилсан ОХУ-ын хоорондын харилцаанд шинэ үе эхлэхийг шаардсан орон зай үүсгэжээ.

### ***IV үе. Зах зээлийн системд шилжсэн Монгол Улс (1991 – 2000 онууд)***

Орос Монголын харилцааны шинэ үеийн утга учир нь хоёр орон ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих эздрээ төвөгтэй гараан дээр монгол-оросын харилцааг бүхэлд нь эрх тэгш, харилцан ашигтай байх, бие биеийн дотоод хэрэгт үл оролцох зарчимд тулгуурлан өөрчлөн хөгжүүлэхэд оршиж байлаа.

<sup>39</sup> Стратеги судлал сэтгүүл 2007 оны № 40, хэвлэл ху“ 84-85 Г Грайворонский/ ОХУ-ын Дорно дахины судалгааны хүрээлэнгийн Монголын секторын эрхлэгч, шинжлэх ухааны доктор профессор/ “Орчин үеийн Монгол улсын талаарх Орос улсын баримталж буй бодлогын зарим онцлог” нийтлэлтээс.

<sup>40</sup> “Монгол, Орос, Хятад: XXI зуунд хөгжлийн төлөө хамтдаа” ху“ №137 сэдэвт олон улсын эрдмийн анхдугаар форум дээр О.Батсайханы (ШУА-ийн Олон Улс судлалын хүрээлэнгийн ЭШАА, секторын эрхлэгч доктор/Sc D/, профессор) Монгол-Оросын харилцааг Уламжлал, шинэчлэл илтгэлтээс.

<sup>41</sup> Стратеги судлал сэтгүүл 2007 оны № 40, хэвлэл ху“ 84-85 Г Грайворонский/ ОХУ-ын Дорно дахины судалгааны хүрээлэнгийн монголын секторын эрхлэгч, шинжлэх ухааны доктор профессор/ “Орчин үеийн Монгол улсын талаарх Орос улсын баримталж буй бодлогын зарим онцлог” нийтлэлтээс.

1990 онд БНМАУ-д тайван замаар ардчилсан хувьсгал гарч, өнөөгийн шинэ ардчилсан Монгол Улсыг бий болгов. Монгол Улсын хувьд ч тэр, ОХУ-ын хувьд ч тэр хоёр талын худалдаа, хамтын ажиллагаа өмнө нь үйлчилж байсан хэвшсэн тогтолцоогоор явуулах боломжгүй болсоныг, энэхүү аж ахуйг эрхлэн хөтлөх төвлөрсөн захиргаадаттын аргаас зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц харуулж байлаа. Энэ үед Орос Монголын харилцаа, хамтын ажиллагаа бараг бүх салбарт зогсонги байдалд орсон гэж болно. Жишээ татахад ЗХУ-аас Монгол Улсад урьд туслаж байсан туслалцааны цар хэмжээ эрс хорогдож хоёр улсын гадаад худалдааны нийт эргэлт 1998 онд 1990 оныхтой харьцуулвал 6 дахин буурсан мэдээ байдаг.<sup>42</sup>

Хоёр улсад өрнөсөн ардчилсан өөрчлөлтийн дүнд Орос Монгол улс хоюулаа нийгмийн шинэ тогтолцоонд шилжин орлоо. Үүний дараа Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат 1993 онд ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалынхаа үеэр “Монгол Улс, Оросын Холбооны Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”-г байгуулсан нь нийгмийн шинэ харилцаанд орсон тус хоёр улсын орчин цагийн харилцааны эрх зүйн үндэс болж өгөх ёстой байлаа.

Монгол Улс 1994 онд баталж, 2011 онд шинэчилсэн “Гадаад бодлогын үзэл баримтлал”-даа “ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ” гэж заасан. Энэхүү заалт үндсэндээ одоо л амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд тэнцвэртэй харилцаана гэдэг нь бүх асуудлаар адил байр суурьтай байхаас гадна итгэлшлэл, ойлголцлыг бэхжүүлэх үндсэн дээр сайн хөршийн найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагааг бүх салбарт идэвхтэй хөгжүүлэхийг хэлнэ.

Монгол улс шилжилтийнхээ эхний хамгийн хүнд үедбиеэ даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого явуулсанаар олон улсын санхүүгийн байгууллага (ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк г.м.) болон АНУ, Япон, Герман, Бүгд Найрамдах Солонгос Улс зэрэг өндөр хөгжилтэй улс орнуудаас хөрөнгө, санхүүгийн туслалцаа авч хөл дээрээ жаахан өндийсөн бол, тэд ч бас үүнийхээ үр дүнд тус улсад эзлэх байр суурь, нөлөөгөө өргөтгөн бэхжүүлж чадсан юм. Мэдээж хэрэг эдгээр улс орон бүрийн цаана Монголын газар нутаг дээр бий болгох юмсан гэсэн өөрсдийнх нь стратеги, геополитик, худалдаа, эдийн засгийн гээд олон янзын ашиг сонирхол байгаа. Өөрөөр хэлбэл Орос Монголын харилцааны хамгийн сул байсан энэ цаг үед, тэр орон зайнд нь «хүйтэн дайн» дууссанаас хойш бүрэлдсэн том гүрнүүдийн хүчний шинэ харьцаа тусгалаа олжээ гэж болно. Тэгээд ч сүүлийн жилүүдийн байдлаас харахад Монгол Улсын өвөрмөц газар зүйн болон геополитик байрлал, түүний нутаг дэвсгэрт шинээр олдсон буюу олдож болзошгүй байгалийн их нөөц баялаг зэрэг нь тус орныг Орос, Хятад, АНУ, Канад, Япон, Өмнөд Солонгос, Герман зэрэг бусад улс орны анхаарал, ашиг сонирхол сүлжилдсэн өрсөлдөөний объект болгож байна.

Үүнээс дүгнэж хэлэхэд Орос Монгол хоёр орны аль аль нь хүсээгүй “харилцааны сулрал”-ын энэ үе тус орнуудын нийгмийн шилжилт, өөрчлөлтийн үетэй нь давхцан тохиожээ.

#### *VI үе. Орос Монголын харилцааны шинэ үе (2001 оноос хойш)*

1974 оны 11 дүгээр сараас хойш хуучин ЗХУ буюу ОХУ-аас төр, засгийн тэргүүний айлчлал хийгдээгүй байсан бөгөөд 2000 оны 11 дүгээр сард Монгол Улсад ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины хийсэн төрийн айлчлал, энэ үеэр хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны чиглэл, зорилтыг тодорхойлсон “Улаанбаатарын Тунхаглал”-д гарын үсэг зурснаар Орос Монголын харилцаа, хамтын ажиллагаа мэдэгдэхүйц идэвхижсэн байна. ОХУ-ын Засгийн газрын дарга М.М.Касьянов Монгол улсад 2002 оны 3 дугаар сард, 2003 оны 6 дугаар сарын сүүлчээр Ерөнхий сайд Н.Энхбаяр ОХУ-д албан ёсны айлчлал тус тус хийж улмаар хоёр орны гүйцэтгэх засаглалын төв байгууллагууд хоорондын харилцаа өмнөх үеэсээ идэвхижиж өргөн хүрээг хамрах болсон.

2003 онд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр ОХУ-д албан ёсоор айлчилсан дүнгийн тухай хамтарсан албан мэдээнд “Сайн хөршийн уламжлалт түншлэлд баттай тулгуурласан Монгол, Оросын харилцааны онцгой шинэ чанар түүхэн шинэ нөхцөлд хадгаласдан хөгжиж байгааг” цохон тэмдэглээд, хоёр талын харилцаа “сайн хөршийн уламжлалт түншлэл”-ийн зарчимд шилжсэнээ зарласан байна.

ОХУ-д төлөх Монголын шилжих рублийн өрийн асуудлыг 2003 оны 12 дугаар сард эцэслэн шийдвэрлэсэн нь харилцан ашигтай төслүүдийг улсын шугамаар зээлжүүлэх, санхүүгийн ажиллагааны хүрээнд чанарын шинэ боломжуудыг нээж өгсөн юм.

Монгол-Оросын хамтын ажиллагааны хөгжлийн хурдац хамрах хүрээ, далайц хоёр оронд өрнөж байгаа олон талт өөрчлөлтүүд, түүний дотор эдийн засгийн өсөлтийн хэрээр өргөжиж байна гэж үзэж

<sup>42</sup> Монгол Улсын статистикийн эмхтгэл. Mongolian Statistical Yearbook 2000, Улаанбаатар, 2001, Т. 177

болохоор байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 онд ОХУ-д хийсэн төрийн айлчлалын үед хоёр улсын харилцааг стратегийн түншлэлийн хэмжээнд хөгжүүлэх тухай тохиролцоонд хүрч, “Москвагийн тунхаглал” байгуулсан бол ОХУ-ын Ерөнхийлөгч Д.Медведевийн 2009 онд Монгол Улсад хийсэн төрийн айлчлалын дүнд “Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх тухай тунхаглал” гаргаснаар хоёр орны харилцаа цаашид урт хугацаанд тогтвортой урагшлан хөгжих хэтийн төлөв нээгдлээ. Стратегийн түншлэл нь Орос Монголын харилцааны түүхэн ололтууд, өнөө болон ирээдүйн хамтын ажиллагааг зохицуулсан, гол чиглэлийг тодорхойлж өгч байгаа ойлголт гэж болно. Монгол-Оросын харилцааг чанарын шинэ шатанд гаргах нөхцөл бололцоо аль аль талд нь бүрджээ.

#### АШИГЛАСАН НОМ

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992
2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 2011
3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль. УБ., 2005
4. И.Дашням. БНМАУ-ын сонгуулийн систем. УБ., 1975
5. А.Жамбал Монгол улс дахь сонгууль сонгуулийн шинэ тогтолцоо. УБ., 2000
6. Монгол улс дахь сонгууль, сонгуулийн шинэ тогтолцоо. Монгол улсын ШУА. ФСЭХ. УБ., 2000
7. Б.Чимэд. Сонгуульд суралцахуй, /тогтолцоо, үйл явц, эрх зүй/ УБ., 2008
8. Сургалт судалгааны прогноз төв. Улс төр ба иргэдийн оролцоо. УБ., 2010
9. Д.Түмэнжаргал. Монголын сонгуулийн систем: эрэл шийдэл. УБ., 2012
10. Д.Баасансүрэн. Сонгуулийн компанийн технологи, УБ., 2013
11. 山东大学当代社会主义研究所. 《当代世界社会主义问题》 [J]. 山东省. 济南市: 1990年. №2
12. 山东大学当代社会主义研究所. 《当代世界社会主义问题》 [J]. 山东省. 济南市: 1990年. №4
13. 中国蒙古国研究会. 《蒙古国研究》[J]. 呼和浩特市: 1999年, 2000年.
14. 中国社会科学院. 《当代亚太》[J]. 北京市: 2006年. №3
15. 吉林大学. 《东北亚论坛》. [J]. 吉林省. 长春市: 2001年. №2
16. 吉林大学. 《东北亚论坛》. [J]. 吉林省. 长春市: 2005年. №5
17. Сонгууль -2000» сэтгүүд. УБ., 2000
18. Монгол улсын ШУА-ын ОУСХ. Герман: судалгаа, мэдээлэл. УБ., 2005
19. Юлиана Петренко. Журнал о выборах. М., 2013. №4
20. Ж.Ядамсүрэн. Монгол улсын сонгуулийн хууль тогтоомжийг боловронгуй болгох нь. Олон улсын бага хурлын эмхтгэл. УБ., 2002
21. Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2009
22. Нийслэлийн сонгогчдын дүр төрх. Судалгааны тайлан. ШУА-ийн ФСЭХ. УБ., 2012